



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ховд сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2022/89/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Улаангом хот
2022 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,
Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь
Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn
Аудитын менежер: М.Бат-Амгалан
Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn
Ахлах аудитор: Т.Намжил
Утас: 70453721, Цахим хаяг: NamjilT@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	2
3. Аудитын тайлан	3
3.1 Ерөнхий зүйл	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Материаллаг байдал	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	16
3.8 Аудитын гол асуудал.....	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
4. Аудитын илрүүлэлт.....	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	18



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

ХОВД СУМЫН СОЁЛЫН
ТӨВИЙН ЭРХЛЭГЧ
З.БЯМБАСҮРЭН ТАНАА

2022.02.25 № УВА-2022/39/НА-СТА-ТЧЗ
танай -ны № -т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ховд сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ховд сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

0200200270

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	11,807,138.80	15,170,631.80
34	УРЬДЧИЛГАА		
34600	Урьдчилж гарсан зардал		
	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө		
312	Банкинд байгаа бэлэн мөнгө		
3121	Төгрөг		
31211	Төрийн сангийн харилцах		
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах		
33	Авлага		
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага		
335	Бусад авлага		
3351	Байгууллагаас авах авлага		
35	БАРАА МАТЕРИАЛ	11,807,138.80	15,170,631.80
35100	Түүхий эд материал		
35110	Тусгай зориулалттай материал		
35130	Эм боох материал		
35200	Дуусаагүй үйлдвэрлэл		
35300	Бэлэн бүтээгдэхүүн		
35400	Хангамжийн материал	11,807,138.80	15,170,631.80
35410	Бичиг хэргийн материал	125,500	125,500
35420	Аж ахуйн материал	11,571,638.80	14,935,131.80
35430	Сэлбэг хэрэгсэл	110,000.00	110,000.00
35440	Түлш, шатах тослох материал		
35450	Барилгын засварын материал		
35460	Хүнсний материал		
35470	Бусад хангамжийн материал		
35500	Биологийн хөрөнгө		
35600	Мал амьтад		
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	680,676,491.41	672,867,802.13
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	680,676,491.41	674,682,544.33
39100	Газар	9,240,000.00	9,240,000.00
39200	Биет хөрөнгө	671,436,491.41	665,442,544.33
39201	Барилга, байгууламж, орон сууц	566,450,475.95	576,900,475.95
39202	Хуримтлагдсан элэгдэл	-27,028,800.79	-40,729,761.07
39203	Авто-тээврийн хэрэгсэл	15,000,000.00	15,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-1,500,000.00	-3,000,000.00
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	65,868,422.00	58,631,502.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-60,274,089.26	-53,081,169.30

39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	24,117,395.30	22,538,377.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-20,413,388.19	-20,049,856.65
39209	Зам, гүүрийн байгууламж		
39210	Хуримтлагдсан элэгдэл		
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж		
39212	Хуримтлагдсан элэгдэл		
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	88,190,625.00	88,190,625.00
39214	Бусад үндсэн хөрөнгө		
39215	Хуримтлагдсан элэгдэл		
39216	Дуусаагүй барилга, байгууламж		
39217	Ном	21,025,851.40	21,042,351.40
39300	Биет бус хөрөнгө		
39301	Програм хангамж		
39302	Хуримтлагдсан элэгдэл		
39303	Бусад биет бус хөрөнгө		
39304	Хуримтлагдсан элэгдэл		
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	692,483,630.21	689,853,176.13
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	4,043,732.00	2,375,854.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	4,043,732.00	2,375,854.00
413	Өглөг	4,043,732.00	2,375,854.00
4131	Ажиллагчидтай холбогдсон өглөг		
4136	Бусад өглөг		
41361	Байгууллагад төлөх өглөг	3,796,732.00	1,950,554.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	247,000.00	425,300.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	688,439,898.21	685,662,579.93
51	Засгийн газрын хувь оролцоо	688,439,898.21	685,662,579.93
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	296,966,996.60	296,966,996.60
51200	Хуримтлагдсан үр дүн	-8,369,440.75	-9,332,016.83
51210	Өмнөх үеийн үр дүн	-8,369,440.75	-8,369,440.75
51220	Тайлант үеийн үр дүн		-962,576.08
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс		
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	399,842,342.36	399,842,342.36
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	692,483,630.21	689,853,176.13

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	180,865,763.67	129,849,500.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	43,642,563.67	15,200,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	43,642,563.67	15,200,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	43,642,563.67	15,200,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,155,000.00	200,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	42,487,563.67	15,000,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө		
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого – Бараа материал		
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	137,223,200.00	114,649,500.00
	Нэмэлт санхүүжилтийн орлого		8,766,300.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж		8,766,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	137,223,200.00	105,883,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	137,223,200.00	105,883,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих		
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	137,522,998.00	130,321,157.24
21	УРСГАЛ ЗАРДАЛ	137,522,998.00	130,321,157.24
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	115,488,217.00	128,604,739.83
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	56,882,090.00	58,390,015.70
210101	Үндсэн цалин	52,557,189.00	53,474,335.70
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал		
210105	Гэрээтийн цалин	4,324,901.00	4,915,680.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,038,136.00	7,531,617.89
210201	Тэтгэврийн даатгал	4,796,873.00	5,215,416.89
210202	Тэтгэмжийн даатгал	564,337.00	574,941.25
210203	ҮОМШӨ-ний даатгал	451,474.00	436,841.19
210204	Ажилгүйдлийн даатгал	111,409.00	145,815.06
210205	Эрүүл мэндийн даатгал	1,114,043.00	1,158,603.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,758,234.00	31,681,276.00
210301	Гэрэл, цахилгаан	854,082.00	322,294.00
210302	Түлш, халаалт	27,904,152.00	31,358,982.00
210303	Цэвэр, бохир ус		
2104	Хангамж, бараа материалын зардал	1,993,000.00	10,980,107.00

Ховд сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210401	Бичиг хэрэг	353,120.00	256,800.00
210402	Тээвэр, шатахуун	962,780.00	1,973,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	360,000.00	200,000.00
210405	Хог хаягдал устгах ,цэвэрлэх		
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	317,100.00	5,650,900.00
210408	Бараа материал акталсны зардал		2,898,507.00
2105	Нормативт зардал		100,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		
210502	Хоол, хүнс		
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		100,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,585,000.00	1,751,500.00
210604	Урсгал засвар	1,585,000.00	1,751,500.00
2107	Томилолт, зочны зардал	314,000.00	42,000.00
210702	Дотоод албан томилолт	314,000.00	42,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,665,215.00	708,695.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,250,800.00	253,120.00
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	90,000.00	216,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	74,000.00	81,675.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	61,015.00	32,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	97,000.00	33,000.00
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс		
210807	Газрын төлбөр	92,400.00	92,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,252,542.00	17,419,528.24
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	17,252,542.00	17,419,528.24
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,034,781	1,716,417.41
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг		
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг		
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,888,800.00	250,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал		
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21,588,800.00	
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	250,000.00
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг	145,981.00	1,466,417.41
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	43,342,765.67	(471,657.24)
	Үйл ажиллагааны бус зардлын дүн		490,918.84

2250001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		490,918.84
	Үйл ажиллагааны бус үр дүн		(490,918.84)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	43,342,765.67	(-962,576.08)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	138,378,200.00	114,849,500.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,155,000.00	200,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,155,000.00	200,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,155,000.00	200,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,155,000.00	200,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	137,223,200.00	114,649,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт		
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		8,766,300.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж		8,766,300.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	137,223,200.00	105,883,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	137,223,200.00	105,883,200.00
	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих		
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	138,378,200.00	114,849,500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	138,378,200.00	114,849,500.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	116,343,419.00	113,133,082.59
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	59,272,682.00	58,423,976.70
210101	Үндсэн цалин	54,960,751.00	53,509,976.70

210102	Нэмэгдэл		
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал		
210105	Гэрээт ажлын хөлс	4,311,931.00	4,914,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,115,659.00	7,533,297,89
210201	Тэтгэврийн даатгал	4,854,649.00	5,215,416,89
210202	Тэтгэмжийн даатгал	565,317.00	578,301,25
210203	ҮОМШӨ-ний даатгал	452,612.00	463,438,19
210204	Ажилгүйдлийн даатгал	112,453.00	117,538.06
210205	Эрүүл мэндийн даатгал	1,130,628.00	1,158,603,50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,520,382.00	33,267,994.00
210301	Гэрэл, цахилгаан	854,082.00	322,294.00
210302	Түлш, халаалт	37,666,300.00	32,945,700.00
210303	Цэвэр, бохир ус		
2104	Хангамж, бараа материалын зардал	1,696,881.00	6,372,229.00
210401	Бичиг хэрэг	243,620.00	250,330.00
210402	Тээвэр, шатахуун	882,171.00	2,054,509.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	360,000.00	200,000.00
210404	Ном хэвлэл	59,090.00	16,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	152,000.00	3,850,890.00
2105	Нормативт зардал	500,000.00	100,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		
210502	Хоол, хүнс		
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	100,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,085,000.00	2,164,610.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,750,000.00	78,830.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	75,000.00	83,300.00
210604	Урсгал засвар	1,260,000.00	2,002,480.00
2107	Томилолт, зочны зардал	262,000.00	133,500.00
210702	Дотоод албан томилолт	262,000.00	133,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,890,815.00	5,137,475.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,568,800.00	4,595,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	90,000.00	216,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	74,000.00	81,675.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	61,015.00	26,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	97,000.00	33,000.00
210806	Мэдээлэл ,технологийн үйлчилгээ		
210807	Газрын төлбөр		184,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,034,781.00	1,716,417.41
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг		
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг		

213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг		
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,888,800.00	250,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал		
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21,588,800.00	
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	250,000.00
	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг		
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг	145,981.00	1,466,417.41
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)		
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)		
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		
2200	Дотоод эх үүсвэрээр		
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)		
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН		
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)		
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	296,966,996.60	399,842,342.36	-50,465,890.42	646343448.54
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	296,966,996.60	399,842,342.36	-50,465,890.42	646,343,448.54
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт				
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт				
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				

7	Өмчид гарсан өөрчлөлт				
8	Зарласан ногдол ашиг				
9	Тайлант үеийн үр дүн			42,096,449.67	42,096,449.67
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	296,966,996.60	399,842,342.36	-8,369,440.75	688,439,898.21
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	296,966,996.60	399,842,342.36	-8369440.75	688,439,898.21
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	296,966,996.40	399,842,342.36	-8,369,440.75	688,439,898.21
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт				
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт				
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
17	Өмчид гарсан өөрчилөлт				
18	Зарласан ногдол ашиг				
19	Тайлант үеийн үр дүн			-962,576.08	-962,576.08
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	296,966,996.60	399,842,342.36	-9,332,016.83	687,477,322.13

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	107,383,200.00	104,616,782.59	2,766,417.41	97.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	107,383,200.00	104616782.59	2,766,417.41	97.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	107,133,200.00	104,366,782.59	2,766,417.41	97.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	59,248,900.00	58,423,976.70	824,923.3	98.6
210101	Үндсэн цалин	54,208,900.00	53,509,976.70	698,923.30	98.7
210102	Нэмэгдэл			0.00	
210104	Урамшуулал			0.00	
210105	Гэрээт ажлын хөлс	5,040,000.00	4,914,000.00	126,000.00	97.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,023,600.00	7,533,297.89	490,302.11	93.9
210201	Тэтгэврийн даатгал	5,554,000.00	5,215,416.89	338,583.11	93.9
210202	Тэтгэмжийн даатгал	617,400.00	578,301.25	39,098.75	93.7
210203	ҮОМШӨ-ний даатгал	493,900.00	463,438.19	30,461.81	93.8
210204	Ажилгүйдлийн даатгал	123,500.00	117,538.06	5,961.94	95.2
210205	Эрүүл мэндийн даатгал	1,234,800.00	1,158,603.50	76,196.50	93.8

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,371,600.00	33,267,994.00	103,606.00	99.7
210301	Гэрэл, цахилгаан	425,900.00	322,294.00	103,606.00	75.7
210302	Түлш, халаалт	32,945,700.00	32,945,700.00	0.00	100.0
210303	Цэвэр, бохир ус			0.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	928,200.00	912,229.00	15,971.00	98.3
210401	Бичиг хэрэг	204,000.00	250,330.00	-46,330.00	122.7
210402	Тээвэр, шатахуун	310,200.00	307,509.00	2,691.00	99.1
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	200,200.00	200,000.00	200.00	99.9
210404	Ном хэвлэл	50,000.00	16,500.00	33,500.00	33.0
210405	Хог хаягдал зайлуулах,хортон мэрэгчдийн устгал,ариутгал	18,000.00		18,000.00	0.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	145,800.00	137,890.00	7,910.00	94.6
2105	Нормативт зардал	100,000.00	100,000.00	0.00	100.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл			0.00	
210502	Хоол, хүнс			0.00	
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	100,000.00	100,000.00	0.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,170,000.00	2,164,610.00	5,390.00	99.8
210601	Багаж, техник, хэрэгсэл	83,700.00	78,830.00	4,870.00	94.2
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	83,300.00	83,300.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	2,003,000.00	2,002,480.00	520.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	133,500.00	133,500.00	0.00	100.0
210702	Дотоод албан томилолт	133,500.00	133,500.00	0.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,157,400.00	1,831,175.00	1,326,225.00	58.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,615,400.00	1,289,200.00	1,326,200.00	49.3
210802	Аудит, баталгаажуулалт,зэрэглэл тогтоох	216,000.00	216,000.00	0.00	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	81,700.00	81,675.00	25.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	26,500.00	26,500.00	0.00	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	33,000.00	33,000.00	0.00	100.0
210806	Мэдээлэл,технологийн үйлчилгээ			0.00	
210807	Газрын төлбөр	184,800.00	184,800.00	0.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал			0.00	
210901	Бараа үйлчилгээний бусад зардал			0.00	
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг			0.00	

2132	Бусад урсгал шилжүүлэг	250,000.00	250,000.00	0.00	100.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал			0.00	
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал			0.00	
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж			0.00	
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг			0.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	250,000.00	250,000.00	0.00	100.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	107,383,200.00	106,083,200.00	1,300,000.00	98.8
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ			0.00	
310002	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих			0.00	
32	Орон нутгийн төсвөөс санхүүжих			0.00	
320001	Орон нутгийн төсвөөс	105,883,200.00	105,883,200.00	0.00	100.0
35	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	1,500,000.00	200,000.00	1,300,000.00	13.3
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,500,000.00	200,000.00	1,300,000.00	13.3
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		8,766,300.00		
21	УРСГАЛ ЗАРДАЛ		8,766,300.00		
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		8,766,300.00		
2104	Хангамж, бараа материалын зардал				
210401	Бичиг хэрэг				
210402	Тээвэр, шатахуун		1,747,000.00		
210406	Бага үнэтэй түргэн элэгдэх зардал		3,713,000.00		
2106	Эд хогшил, урсгал засварын зардал				
210601	Багаж, техник, хэрэгсэл				
210604	Урсгал засвар				

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		3,306,300.00		
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ				
2132	Бусад урсгал шилжүүлэг				
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал				
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		8,766,300.00		
31	Нэмэлт санхүүжилтийн орлого		8,766,300.00		
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж		8,766,300.00		
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө				
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого				

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Ховд сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Намжил гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Ховд сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Ховд сумын Соёлын төв нь Соёлын үнэт зүйлийг өвлөн хамгаалж түгээн дэлгэрүүлж бүх нийтэд соёл урлагийн боловсролыг эзэмшүүлж авьяас билгийг нээн хөгжүүлж орон нутгийн болон аймаг бүсийн хэмжээнд соёл урлагийн үйлчилгээг иргэдэд хүргэж соёлын өв уламжлалыг хүүхэд залуучуудад сурталчлан таниулж өвлүүлэн үлдээхэд чиглэсэн үйл ажиллагааг явуулдаг байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагатай гэж үзэж шалгахад Ховд сумын Соёлын төвийн 2021 оны үйл ажиллагаанд дотоод хяналт хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ховд сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд Ховд сумын Соёлын төвийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 137,522.9 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 1,375.2 мянган төгрөгөөр тооцсон, гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 130,321.1 мянган төгрөгийн 1 хувиар буюу 1,303.2 мянган төгрөгөөс 80 хувиар тогтоож 1,042.6 мянган төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлан гарах цагалбарт хугацаа болоогүй байсан тул материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар дахин шинэчлэн тогтоосон.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Ховд сумын Соёлын төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4,445.1 мянган төгрөгөөр буюу 0.6 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага			
Урьдчилгаа			
Бараа материал	11,807.1	15,170.6	3,363.5
Үндсэн хөрөнгө	680,676.4	672,867.8	-7,808.6
Нийт хөрөнгө	692,483.6	688,038.4	-4,445.2
Өр төлбөр	4,043.7	2,375.8	-1,667.9
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	688,439.8	685,662.5	-2,777.3
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	692,483.6	688,038.4	-4,445.2

Бараа материалын дансны үлдэгдэл 15,170.6 мянган төгрөг болж 3,363.5 мянган төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй бараа материал хүлээж авснаас шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй.

Оны эцэст бараа материалын нөөц нэмэгдсэн нь хангамжийн материалын өсөлт байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 672,867.8 мянган төгрөг болж 7,808.6 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгө акталснаас шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн худалдан авалтаар 16.5 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 11,900.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө акталж устгасан 10,265.9 мянган төгрөгөөр хасагдсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 2,375.9 мянган төгрөг болж 1,667.9 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны түлш халаалт, томилолтын өр буурсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 685,662.5 мянган төгрөг болж 2,777.3 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгө акталснаас шалтгаалжээ.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 51,016.2 мянган төгрөгөөр буюу 28.2 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс үнэ төлбөргүй хүлээж авсан орлого, үндсэн үйл ажиллагааны орлого буурсан байна.

Нийт зардал өмнөх оноос 7,201.8 мянган төгрөгөөр буюу 5.2 хувиар буурсан байна. Нийт зардал буурахад байр ашиглалттай холбоотой зардал, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардал голчлон нөлөөлжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 151,197.5 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 151,197.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 43,814.3 мянган төгрөгөөр бууруулж 107,383.2 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 107,383.2 мянган төгрөгийн төсөв баталснаас 105,883.2 мянган төгрөгийг улсын төсвөөс, 1,500.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор, нийт 107,383.2 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 105,883.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 200.0 мянган төгрөг, нийт 106,083.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 104,616.8 мянган төгрөгийг зарцуулсан байна. Үндсэн үйл ажиллагааны данснаас 1466.4 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 104,616.8 мянган төгрөг буюу 97.4 хувьтай байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламжаас 8,766.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс тээвэр шатахууны зардалд 1,747.0 мянга, урлаг, уран бүтээлийн зардалд 3,713.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний зардалд 3,306.3 мянга, нийт 8,766.3 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар чиглэлийн дагуу Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх онд зөвлөмж, албан шаардлага өгсөн болон эрсдэл бүхий байгууллагыг түүвэрт хамруулан шалгасан. Ховд сумын Соёлын төвийн хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй байсан тул Шилэн дансны үйл ажиллагаа, мэдээлэлд хийх нийцлийн аудитаар шалгах аар шийдвэрлэв.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 114, хугацаа хоцроож мэдээлсэн 36, мэдээлэх хугацаа болоогүй 1 мэдээлэл байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчилтэй асуудал байхгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР /Т.НАМЖИЛ/

2022 оны 02 сарын 23-ны өдөр